



# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1997 оны 3 дугаар  
сарын 11 одөр

Дугаар 6-63

Улаанбаатар  
 хот

Соёлын газрын дүрэм батлах,  
ажилд томилох тухай

1. Монгол улсын Засгийн газрын 1996 оны 263 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 1997 оны Б/18 дугаар захирамжийг үндэслэн нийслэлийн Соёлын газрын дүрмийг хавсралтваар баталсугай.

2. Соёлын газрын даргаар Гүндийн Нямсамбууг 1997 оны 03 дугаар сарын 12-ноос томилж, сарын үндсэн цалинг 34950 төгрөгөөр, нэмэгдлийг үндсэн цалингийн 60 хувиар бодож тогтоосугай.

3. Газрын албан хаагчдыг ажилд томилж, цалин нэмэгдлийг холбогдох журмын дагуу тогтоож ажиллахыг Соёлын газар (н.Нямсамбуу)-т даалгасугай.



*Доржнамзажирж НАРАНЦАРЛАТ*

Нийслэлийн Засаг даргын 1997 оны  
6-р тугаар захирамжийн хавсралт.

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СОЁЛЫН ГАЗРЫН ДҮРЭМ**

УХЕЗИИ

Нэг. Нийтлэг үндэспэл

1.1. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх соёлын газар нь нийслэлийн хөдөлмөрчдийн соёлын үйлчилгээг сайжруулах, уран сайхны боловсролыг дээшлүүлэх, соёл урлагийг хөржүүлэх, түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, тэр засгийн бодлого шийдвэрийг олон түмэнд сурталчлах Засаг даргын харьяа хэрэгжүүлэгч байгууллага мөн.

1.2. Үйл ажиллагаанд Монгол улсын төрөөс Соёлын талаар баримтлах бодлого, соёлын хууль, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэрийг мөрдлөг болгон ажиллана.

1.3. Соёлын газар нь нийслэлийн Засаг дарга түүний Тамгын газрын харьяанд үйл ажиллагаагаа явуулж, ажлаа тайлагнана.

1.4. Соёлын газрын бутэц, зохион байгуулалт, орон тооны хязгаарыг нийслэлийн Засаг дарга тогтоож, даргыг нь томилж, чөлөөлнө.

Соёлын газрын дарга нь батлагдсан орон тооны хязгаарын дотор ажилтнуудаа томилж, эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргана.

1.5. Үйл ажиллагаагаа явуулахад тэмдэг, албан бичгийн хэвлэмэя хуудас хэрэглэнэ.

Хоёр. Соёлын газрын үүрэг:

2.1. Соёл урлагийн талвар гарсан хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргын шийдвэр, захирамжийг нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэнд хяналт тавина.

2.2. Нийслэлийн хөдөлмөрчдийг соёл урлагаар үйлчлэх, соёлын байгууллагуудаас зохиох ажлын биелэлтэнд хяналт тавьж ажиллах.

2.3. Соёлын төв, номын сан, кино театр, музейд зохиогдох ажлыг тэр засгийн бодлого шийдвэрийг хөдөлмөрчдөд сурталчлах ажилтай хослуулан, олон түмнийг цаг үеийн мэдээллээр хангах үүрэг бүхий нийслэлийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтын зорилго чиглэлтэй ажиллах.

2.4. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг соёл урлагийн байгууллагуудтай өмчийн хэлбэр үл харгалзан Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай болон нийслэлийн эрх зүйн байдлын хуулийг хэрэгжүүлэх шаардлагын хүрээнд хамтран ажиллах.

2.5. Соёлын байгууллагын ажилтнуудыг тогтворт суурьшил, үр бүтээлтэй ажиллуулах, тэдний хөдөлмөрлөх нехцлийг сайжруулах, мэргэжил боловсролыг нь дээшлүүлж ажлын арга барилыг боловсронгуй болгохтой холбогдсон арга зүйн сургалт, семинар зохион байгуулах.

2.6. Ардын уламжлалт соёл, ёс заншлыг түгээн уламжлуулах, энэ ажилд соёл урлагийн байгууллагын ажилтнууд, өрдүн авьяастнуудыг зохион байгуулалттай оролцуулах.

2.7. Нийтийн хамарсан уран сайхны хөдөлгөөнийг бүх талаар дэмжин хөгжүүлэх урлагийн үзлэг наадам, уралдаан тэмцэн, соёл урлагийн баяр, өдрүүдийг зохион байгуулж байх.

2.8. Нийлэл, дүүргийн хамгаалалтанд байгаа түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах, сурталчлахай холбогдон гарах харилцааг зохицуулан хэрэгжүүлэх.

2.9. Соёл урлагийг хөгжүүлэх, ажилтнуудын эрх ашгийг хамгаалах үүрэг бүхий уран бүтээлийн эвлэл холбоод, үүсгэл санаачилгын байгууллагатай соёлын бодлогыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах.

2.10. Соёл урлагийн байгууллагуудын ажил үйлчилгээний талаар иргэдээс гаргасан санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч барагдуулах.

2.11. Нийслэл хотын гудамж талбайн чимэглэл, өргөн олныг хамарсан баяр ёсполын арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

2.12. Нийслэл хот, дүүргүүдийн соёлын бодлого, соёлын байгууллагын бүтэц зохион байгуулалтын асуудлаар нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд асуудал боловсруулан оруулж шийдвэрлүүлэх.

#### Гурав. Соёлын газрын эрх:

3.1. Соёл урлагийн ажил үйлчилгээтэй холбоотой асуудлаар албан байгууллага, хувь хүмүүсийн ажлыг шалгаж зааварчлах, үүрэг даалгавар өгөх, биөлэлтийг хангуулах, мэдээ тайлан гаргуулах,

3.2. Өөрийн аппаратын ажилтнууд болон харьяа байгууллагын удирдлагыг томилох, дүрэм ажил үүргийн хуваарийг баталж цалинг тогтоох,

3.3. Соёлын төлбөрт үйлчилгээ, сайн дурын үүсгэл санаачлагаар байгуулагдсан хамтлаг, чуулагд зөвешеөрөл олгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих.

3.4. Соёл урлагийн талаар бусад орны холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ, хэлцэл байгуулан хэрэгжүүлэх,

3.5. Соёл урлагийг хөгжүүлэх үйлсэд тодорхой хувь нэмэр оруулсан хүмүүсийг Монгол улсын төр засгийн болон улс олон нийтийн байгууллага, нийслэлийн Засаг даргын шагналаар шагнуулахаар тодорхойлох, өөрийн мэдлийн шагналаар урамшуулах,

3.6. Соёл урлагийн салбарын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, олон түмний соёл, уран сайхны боловсролыг дээшлүүлэх санал боловсруулан холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх,